

Тvvхийн шинжлэх ухааны доктор, профессор, цэргийн тvvхч Д.Гомбосvрэнгийн нэрэмжит цэргийн тvvхийн судалгааны шилдэг бvтээлд олгох шагналыг гэр бvл, vр хvvхдvvдээс нь санаачлан бий болгосон богоод анхны шагналыг 2012 онд олгож байсан юм. Энэхvv шагналыг хоёр жил тутамд цэргийн тvvхийн шилдэг бvтээлд олгож байхаар тогтсон богоод 2014 оны шилдэг бvтээлийн шагнал гардуулах ёслол 5 дугаар сарын 14-нд БХИС-ийн “Их эе” танхимд боллоо.

Цэргийн тvvхч Д.Гомбосvрэнгийн нэрэмжит цэргийн тvvхийн судалгааны шилдэг бvтээл олгох ёслолын ажиллагаанд тvvний охин Г.Тэмvвлэн, хvv Г.Хэрлэн, БХЯ-ны ШУТЗ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга доктор, хошууч Л.Оюунцэцэг, ШУА-ийн Тvvхийн хvрээлэнгийн орчин veийн монголын тvvхийн салбарын эрхлэгч доктор, дэд профессор Н.Хишигт, тус хvрээлэнгийн Монголын эртний тvvх, сурвалж судлалын салбарын эрхлэгч доктор С.Олзийбаяр, ШУА-ийн Археологийн хvрээлэнгийн Хvрэл, тvрvv томрийн veийн археологийн судалгааны секторын эрхлэгч, доктор Н.Батболд, БХИС-ийн захирал хошууч генерал, дэд профессор Я.Чойжамц, эрдэм шинжилгээ, доктор, магистрын сургалтын албаны дарга, доктор, дэд хурандаа Ж.Хvрэл, Нийгэм хvмvvnлэгийн тэнхимийн багш нар, БХЭШХ-ийн захирал, шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал О.Yржин, тус хvрээлэнгийн эрдэмтэн судлаачид оролцлоо.

Энэ жилийн нэрэмжит шагналаар Оросын ШУА-ийн Сибирийн салбарын Археологи, угсаатан судлалын хvрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Новосибирскийн Улсын их сургуулийн Археологи, угсаатан судлалын тэнхимийн эрхлэгч, Оросын Байгалийн ШУА-ийн академич, археологич, зэвсэг судлаач Ю.С.Худяков, ШУА-ийн Археологийн хvрээлэнгийн Хvрэл, тvрvv томрийн veийн археологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан доктор Н.Эрдэнэ-Очир нарын туурвисан “Военное дело древних кочевников Монголии (II тысячелетия-III век до.н.э)” хэмээх хамтын бvтээл шалгарч оргомжлол, монгон шагналаар шагнуулав.